APN
ASIA-PACIFIC NETWORK FOR
GLOBAL CHANGE RESEARCH

FINAL REPORT

Project Final Report: Sulfur isotopic approach on sources and production of urban atmospheric particulate matters in East Asia

CRECS2020-01MY-Tseren-Ochir

2022

Project Reference Number: CRECS2020-01MY-Tseren-Ochir

Project Duration: 2 years

Funding Awarded: USD30,000

Grant DOI: https://doi.org/10.30852/p.13784

Date of Publication: 12 October 2022

Project Leader and Contact Details:
Soyol-Erdene Tseren-Ochir, National University of Mongolia, Mongolia
soyolerdene@seas.num.edu.mn

Collaborators and Contact Details:
Jing Chen, Beijing Normal University, China
jingchen@bnu.edu.cn

Dongmei Hu, North China Electric Power University, China
huhu3057@163.com

Recommended Citation:

Soyol-Erdene, T. O., Chen, J. & Hu, D. (2022). Project Final Report: Sulfur isotopic approach on sources and production of urban atmospheric particulate matters in East Asia. Technical Report. Asia-Pacific Network for Global Change Research.

1. Summary

Many cities in East Asian countries suffer severe haze pollution due to rapid urbanisation, industrialising, and increasing population. Recent research shows that PM2.5 composition in Ulaanbaatar (UB) and Beijing is highly affected by coal combustion sources, which contribute to local and regional atmospheric pollution. Besides, there are many unidentified sources, which become an obstacle to haze pollution mitigation.

The main objective of this study is to assess the source contributions of PM2.5 based on approaches of isotopes and other components in PM2.5 collected at Ulaanbaatar and Beijing. We performed intensive PM2.5 sampling from Ulaanbaatar and Beijing and adopted a sample pre-treatment method for isotope analyses. Then, the analytical conditions of the N isotopes were optimised. Daily PM2.5 sampling was conducted for two weeks each season, and the chemical components of PM2.5 (ions, carbonaceous compounds, trace elements) and N isotopes in nitrate were analysed. Regional and seasonal characteristics of the chemical components of PM2.5 were clarified. Primary sources are distinguished coupling chemical components, N isotopes and simulations. Finally, N isotopes (14N and 15N) of nitrate in PM2.5 aerosols are discussed to understand better the sources and formation of nitrate, which can be crucial for improving the air quality in East Asia.

Modelling secondary organic aerosol (SOA) has remained a significant challenge due to the various precursors and complex processes. In this study, the WRF-CAMx model was also used to predict the ambient SOA concentrations in urban Beijing and the North China Plain (NCP) during a polluted period in winter. Both the volatility basis set (VBS) approach and the two-product approach (SOAP) were used for SOA simulation. Although the modelled SOA was underpredicted compared with the SOA estimated by the OC/EC method, the VBS scheme produced higher SOA than the traditional two-product scheme. According to the sensitivity tests with the VBS scheme, the emissions of volatile organic compounds (VOC), intermediate volatility organic compounds (IVOC), and oxidant levels were the key factors that affected SOA prediction.

In comparison, the predicted SOA was less affected by primary organic aerosol (POA) emission and chemical aging during the wintertime. The potential contributions from different anthropogenic sources and source areas were also identified using the brute-force method. Over 80% of SOA in urban Beijing resulted from regional transport of SOA or its precursors from the surrounding areas during the polluted period. Residential emissions in the North China Plain appeared as the dominant source of SOA in urban Beijing from the perspective of regional contribution.

During the cold season, the air pollution level in Ulaanbaatar, the capital of Mongolia, is frequently ranked as the highest in the world. However, due to the lack of air quality management, the country is suffering from a deterioration of air quality. Despite the worse air pollution situation, due to the insufficient research capacity of the country, to date, research works on characteristics of air pollution have mainly been based on current capability and/or collaboration with foreign institutes. The research gap in this area necessitates numerous investigations, which could have great importance in developing mitigating strategies and

minimising the adverse impact of air pollution on local and regional scales. We reviewed previously available studies and reports in international scientific journals on air quality in Mongolia. Based on the current research works, future needs of studies on ambient air pollution in Mongolia are suggested.

2. Objectives

The project aims to investigate the emission characteristics, distributions, and sources of atmospheric particulate matter in major cities of Mongolia and China (Ulaanbaatar and Beijing). Through the analyses of ions, carbonaceous compounds, trace elements and stable isotopes of atmospheric particulate matter, the specific objectives are:

i) To enhance the capability of early career researchers to set up isotope geochemical and model studies on atmospheric chemistry.
ii) To assess the transboundary air pollution mechanism between Mongolia and China by chemical and isotopic analyses and to identify the emission sources, transport and impacts of air pollutants on ambient air.
iii) To suggest pollution control strategies and policies via science-policy interactions and scientific publications.

3. Outputs, Outcomes and Impacts

Outputs	Outcomes	Impacts
Installed laboratory facilities for aerosol analyses at the National University of Mongolia	More laboratory capacity to perform aerosol chemistry research	Improve higher education quality in Mongolia
Developed methods for aerosol sampling, pre-treatment, and analyses	More accurate and precise analyses of the chemical composition of PM	Improve the quality of life in individuals through research result
Distinguished major sources of nitrate in PM2.5	More knowledge in nitrate sources for Ulaanbaatar and Beijing	Reduction of air pollutants emission
Predicted concentrations of secondary organic aerosols in Urban Beijing and North China plain	More knowledge sources secondary organic aerosols in Urban Beijing and North China plain	Slowing of climate change
Reviewed previously studies and suggested future needs of studies on ambient air pollution in Mongolia	Clear information of current knowledge and needs of studies	Improve achievement of air pollution measures

4. Key facts/figures

- Six laboratory basic equipment and analytical instruments were installed
- A standard method for PM sampling, preparation, pre-treatment and analyses for ionic and metal composition is tested in a lab at the National University of Mongolia (1 laboratory standard protocol)
- Two early-career professionals trained
- Three peer-reviewed publications: published (1); submitted (1); in preparation (1)
- Three events: workshops (2); training event (1)

5. Publications

Papers

Soyol-Erdene, T. O., Ganbat, G., & Baldorj, B. (2021). Urban Air Quality Studies in Mongolia: Pollution Characteristics and Future Research Needs. Aerosol and Air Quality Research, 21(12), 210163. doi: 10.4209/aaqr.210163

Dambajamts, N., Ulziibat, B., Natsagdorj, A., Tuuguu, E., Altantsetseg, D., B. Baldorj, & Soyol-Erdene, T.O. (2021). Chemical compositions of fine aerosols (PM2.5) in Ulaanbaatar, Mongolia. Issues of Mongolian Geography and Geoecology 42. (In Mongolian).

Zhang, Y., Huang, H., Qin, W., Yu, Q., Cheng, S., Ahmad, M., Ouyang, W., Soyol-Erdene, T.O. & Chen, J. (2022). Modelling of wintertime regional formation of secondary organic aerosols around Beijing: sensitivity analysis and anthropogenic contributions Carbon Research. (*under review*).

Ke Xi, Jing Chen, Tseren-Ochir Soyol-Erdene, Weihua Qin, Siming Cheng, Yuewei Sun, Qing Yu, Jing Ai, Ulziibat Bilguun, Narmandakh Dambajamts. Formation mechanism and source apportionment of nitrate in PM2.5 in Ulaanbaatar and Beijing: comparing results between Bayesian Isotopic Mixing Model and Positive Matrix Factorization Model. *(In prep).*

Presentations

Natsagdorj, A., Soyol-Erdene, T.O., Lee, Y., & Tugsbayan, B. (October 2021). Seasonal Variations of Aerosol Composition and Sources of PM2.5 in Ulaanbaatar, Mongolia, Meeting of Korean Society for Atmospheric Environment.

Dambajamts, N., Ulziibat, B., Tuuguu, E., Natsagdorj, A., Daichaa, D., Altantsetseg, D. & Soyol-Erdene, T.O. (October 14, 2021). Chemical compositions of fine aerosols (PM2.5) in Ulaanbaatar, Mongolia. 5th International Conference on Chemical Investigation and Utilisation of Natural Resources, Ulaanbaatar, Mongolia.

6. Media reports, videos and other digital content

Not available

7. Pull quotes

I did my master's thesis work on this project. I learned many things about air pollution issues in Northeast Asia. The project grant gave me an excellent opportunity to make my master's thesis successfully - D. Narmandakh (Masters's Degree student)

8. Acknowledgments

We thank the researchers at the Central Laboratory of Environmental Monitoring, National Agency of Meteorology and Environmental Monitoring, Mongolia, for supporting part of the sampling.

9. Appendices

Appendix 1. PM sampling and treatment protocol

Appendix 2. Abstract of domestic conference (paper title: *Sources and chemical composition of atmospheric fine particulate matter in Ulaanbaatar, Mongolia*)

Appendix 3. Domestic paper (paper title: *Chemical composition of atmospheric fine particulates (PM2.5) in Ulaanbaatar, Mongolia*)

Appendix 4. SCI paper

Appendix 5. Manuscript SCI paper (in preparation)

Appendix 6. Manuscript SCI paper (under review)

Appendix 7. Abstract of international conference

Appendix 1. PM sampling and treatment protocol

ОРЧНЫ АГААРААС НАРИЙН ШИРХЭГЛЭЛТ ТООСОНЦРЫН СОРЬЦ ЦУГЛУУЛАХ, СОРЬЦЫГ ХАДГАЛАХ, ШИНЖИЛГЭЭНД БЭЛТГЭХ СТАНДАРТ АЖЛЫН ЗААВАР

Хүрээлэн буй орчны хими, геохимийн лаборатори	**Тодорхойлох үзүүлэлт**	**Шинэчлэгдсэн дугаар**	**Огноо**	**Сорил туршилтын аргын НТББ**
	PM2.5 масс агууламж Органик бохирдуулагчид (ПАН) Металл Уусдаг органик биш ионууд	01	2020.10.21	ISO16362 USEPA13A USEPA I.O. 3.1

Боловсруулсан:

Ц.Соёл-Эрдэнэ МУИС, Хүрээлэн буй орчны хими, геохимийн лабораторийн удирдагч, доктор

Б.Бархасрагчаа БОАЖЯ, ЦУОШГ-ийн харъяа Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн агаарын хэсгийн ахлах инженер, магистр

Ц.Хулан МГАМДС-ийн туслах багш, магистр

Б.Барсболд МУИС, Хүрээлэн буй орчны хими, геохимийн лабораторийн ЭША

Д.Нармандах МУИС, Хүрээлэн буй орчны хими, геохимийн лабораторийн ЭША

ОРЧНЫ АГААРААС НАРИЙН ШИРХЭГЛЭЛТ ТООСОНЦРЫН СОРЬЦ ЦУГЛУУЛАХ, СОРЬЦЫГ ХАДГАЛАХ, ШИНЖИЛГЭЭНД БЭЛТГЭХ СТАНДАРТ АЖЛЫН ЗААВАР

Хүрээлэн буй орчны хими, геохимийн лаборатори	Тодорхойлох элемент	Шинэчлэгдсэн дугаар	Огноо	Сорил туршилтын аргын НТББ
	PM2.5 масс агууламж Органик бохирдуулагчид (ПАН) Металл Уусдаг органик биш ионууд	01	2020.10.21	ISO16362 USEPA13A USEPA I.O. 3.1

Хамрах хүрээ: Энэ арга нь агаар дахь тоосонцрын сорьц цуглуулах, тоосонцорт агуулагдах уусдаг ионууд, хүнд металлууд, органик бохирдуулагчид (олон цагирагт үнэрт нүүрсустөрөгчид)-ын агууламжийг тодорхойлоход зориулж усан ханд бэлтгэх, бичил болгионы зууханд хүчлээр хандлах, органик уусгагчаар хандлах үйл явцад хамаарна.

1. ОРЧНЫ АГААРААС ИХ ЭЗЭЛХҮҮНТЭЙ СОРЬЦ АВАГЧ АШИГЛАН НАРИЙН ШИРХЭГЛЭЛТ ТООСОНЦОР (PM2.5)-ЫН СОРЬЦ ЦУГЛУУЛАХ АРГА

Аргын зарчим: Агаарыг насосоор тодорхой хурдтайгаар соруулан, фильтр дундуур нэвтрүүлж тоосонцрыг фильтрийн цаасанд тогтоон барихад үндэслэнэ. Хоосон ба сорьцтой фильтрийн жингийн зөрүү, сорсон агаарын эзэлхүүнд үндэслэж агаар дахь тоосонцрын агууламжийг тооцоолно.

Саад болох хүчин зүйлс: Агаарын тоосонцрыг аэродинамик диамертээр ялган сорьцлоход ялгагч чухал үүрэгтэй тул ялгагч зөв ажиллаж буй эсэхийг тогтмол хянах хэрэгтэй. Агаарын бохирдуулагчдын (тоосонцрын болон түүнд агуулагдах химийн бүрэлдэхүүний) агууламжийг тоуоооход сорьцолсон агаарын эзэлхүүн чухал тул агаар сорогчийн хурд тогтмол бөгөөд зөв хэмжигдэж байх шаардлагатай.

1.1 Хэрэглэгдэх материал, урвалжууд

- Сорьц авах филтьр
- Хямсаа
- Бээлий
- Сорьцын гэр (мөнгөлөг цаас)
- Сорьц тээвэрлэх хайрцаг
- Сорьц хадгалах хайрцаг

1.2 Тоног төхөөрөмж

- Электрон жин

- Шатаах зуух
- Десикатор (Хавсралт 1, Зураг 1)
- Их эзэлхүүнт сорьц авагч (Хавсралт 1, Зураг 2)

1.3 Фильтрийг сорьц авахад бэлдэх, жинлэх

- Шинжилгээнд тохирсон материалтай фильтрийг сонгоно (Хавсралт 2).
- Бүх төрлийн фильтрүүдийг ашиглан сорьц авахын тулд урьдчилсан боловсруулж бэлтгэх шаардлагатай байдаг. Үүнд: массын хэмжилтэд чийгийн нөлөөллийг арилгахын тулд фильтрийг нөхцөлжүүлэх үйл ажиллагаа, кварц фильтрт шингэсэн байж болзошгүй органик уурыг арилгахад урьдчилан жигнэх үйл ажиллагаанууд хамаарна.

1.3.1 ***Фильтрийг нөхцөлжүүлэх/filter conditioning/***

- Фильтрт цугларсан тоосонцрын масс агууламжийг тодорхойлохын тулд сорьц авахын өмнө болон сорьц авсны дараа температур чийгийн хяналттай орчинд фильтрийг өндөр нарийвчлалтайгаар жинлэх шаардлагатай байдаг. Тоосонцрыг хэмжих стандарт аргачлалын дагуу тогтмол температур (20°C ~ 23°C) ± 2°C чийгшилтэй (30% ~ 40%) ± 5% орчинд 24-48 цагийн турш нөхцөлжүүлэх шаардлагатай гэж үздэг. Энэ нь сорьц дахь ууршимтгай нэгдлүүдийн алдагдлыг багасгах болон усны уурын нөлөөллийг багасгах зорилготой юм. Сорьц авахад ашиглах шинэ фильтрийг зориулалтын саванд хийж (савны тагийг нээж фильтрийн орчим агаар чөлөөтэй сэлгэж байхаар байрлуулна) тоосгүй орчинд нөхцөлжүүлнэ. Фильтрийн нөхцөлжүүлэх хугацаанд савны тагийг хагас нээлттэй байлгана. Энэ үйл ажиллагааны үед хөндлөнгийн нөлөөлөлд өртсөн эсэхийг тогтоохын тул лабораторийн бланк фильтрийг ашиглана.

1.3.2 ***Кварц фильтрийг хатаах/filter baking/***

- Кварц материалаар хийгдсэн фильтр нь органик уурыг үргэлж шингээж байдаг. Иймд фильтр шингэсэн органик уурыг арилгахын тулд хэмжилтэнд ашиглахын өмнө шатаах зууханд 550℃ температурт 4 цагийн турш шатаана. Хатаасан/жигнэсэн фильтрүүдийг органик уур дахин шингээхээс сэргийлж мөнгөлөг цаасаар доторлосон зориулалтын саванд хийж тагийг сайтар битүүмжлэн сорьц авах хүртэл хөргөгчинд хадгална.

1.4 Фильтрийг жинлэх

- Жинг чичиргээ доргион, агаарын урсгалаас сайтар тусгаарласан, мөн лабораторийн өөрийн агаараас тоос тоосонцор, хий шинжилж буй фильтр нөлөөлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байдаг.
- Жингийн аргаар фильтрийн массыг тодорхойлох ажилд саад бологч хүчин зүйл нь статик цэнэгийн нөлөөлөл байдаг. Фильтр дээрх үлдэгдэл цэнэг нь статик цэнэг үүсгэж жингийн металл хэсгүүдтэй үйлчлэлцсэнээр хүндийн хүчний бус нөлөөллийг үүсгэдэг. Иймд фильтрийг жинлэхийн өмнө статик цэнэг арилгагч ашиглаж хэмжлийн алдааг багасгана.
- Фильтрийг электрон жин дээр 3 удаа жигнэж, жинг тэмдэглэж авна. Тооцоонд дундаж утга ашиглана.

1.5 Сорьц авах

- Сорьц цуглуулах фильтр бүрийг лабораторид шошголж, хямсаа ашиглан тохирох фильтрийн гэрэнд байрлуулна. Шошго бүрэн, тод, зөв хийгдсэн эсэхийг шалгана.
- Агаар нэвтрэхгүй саванд (хайрцагт) байрлуулж сорьц авах газар руу аваачина.
- Сорьц авах цэг дээр фильтрийг гэрнээс гаргаж, сорох хоолойтой холбогдсон сорьц авагчийн толгойд хийж бэхэлнэ.
- Зорилгоос хамаарч сорьц авах хугацааг 1-ээс 24 цаг хүртэл тохируулна.
- Сорогч насос болон хугацаа хэмжигчийг ажиллуулна.
- Хэрэв урсгал хянах төхөөрөмжийг нийт эзэлхүүн хэмжигчтэй хослуулан хэрэглэвэл сорьцийн эзэлхүүнийг сорьц авах хугацааны эхэн ба төгсгөлд эзэлхүүний тоолуурын заалтын зөрүүгээр гаргана.
- Хэрэв урсгал хянах төхөөрөмжийг урсгалын хурдыг хэмжих төхөөрөмжтэй хослуулсан бол сорьцийн эзэлхүүнийг дундаж урсгалын хурд (хэмжилтийн хугацааны эхэн ба төгсгөлд хамгийн багадаа урсгалын хурднаас тооцоолно) ба сорьцилсэн хугацаанаас тооцоолно.
- Сорьц авах хугацааны эхэн ба төгсгөлд урсгал хэмжих төхөөрөмжийн ажиллагааг шалгахын тулд урсгалын хурд хэмжигч төхөөрөмжийг ашиглах хэрэгтэй.
- Сорьц авсны дараа насосыг унтраана.
- Сорьц авагчийн толгойноос фильтртэй фильтр тогтоогчийг гаргаж авна.
- Сорьц бүхий фильтрийг мөнгөлөг цаасан гэрэнд буцаан хийж, агаар нэвтрэхгүй тээвэрлэх саванд (тээвэрлэх хайрцагт) байрлуулан, сорьц бүхий талыг дээш харуулан тээвэрлэнэ.
- Тээвэрлэх сав (хайрцаг) -ыг хэвтээ байдлаар тээвэрлэх хэрэгтэй.
- Лабораторид ирсний дараа сорьц бүхий фильтрийг гэрнээс хямсаа ашиглан гаргана.

1.6 Сорьц бүхий фильтрийг хадгалах, жинлэх

- Сорьц авсан фильтрийн тоос хуримтлагдсан талыг дээш харуулан зориулалтын саванд хийж жинлэх хүртэл лабораторийн хөргөгчинд (4°C) хадгалж болно. Дэгдэмхий органик бохирдуулагч (ПАН зэрэг) тодорхойлох бол сорьцийг -20ºC-ээс бага температурт хадгална.
- Сорьц бүхий савны тагийг нээхээс өмнө тасалгааны температурт 1-2 минут байлгах хэрэгтэй. Учир нь тагийг шууд нээвэл хөргөгчнөөс гарч ирсэн хүйтэн фильтр дээр усны уур конденсацлагдах сөрөг нөлөөтэй байдаг.
- Сорьц авснаас хойш нэг жилийн дотор шинжилгээ хийнэ.
- Сорьцын 10-аас доошгүй хувьд, эсвэл тухайн цэгт 10-аас цөөн сорьц авсан бол багадаа нэг ширхэг хоосон (бланк) сорьц авна. Бланк сорьцийн фильтрийн сорьцтой адил нөхцөлжүүлнэ.
- Сорьц бүхий фильтрийг жинлэхийн өмнө мөн өмнөхтэй ижил нөхцөлд нөхцөлжүүлэх ба савны тагийг нээхээс өмнө тасалгааны температурт 1-2 минут байлгах хэрэгтэй. Учир нь тагийг шууд нээвэл хөргөгчнөөс гарч ирсэн хүйтэн фильтр дээр усны уур конденсацлагдах сөрөг нөлөөтэй байдаг.

- Сорьц бүхий фильтрийг электрон жин дээр 3 удаа жигнэж, жинг тэмдэглэж авна. Тооцоонд дундаж утга ашиглана.

Фильтртэй ажиллах

- Фильтртэй зөвхөн зориулалтын хуруувч эсвэл винил (нунтаггүй)-ийн бээлийтэй ажиллана. Энэ журмыг хээрийн сорьцлолтийн үед болон жингийн өрөөнд заавал мөрдөнө.
- Фильтр дэх сорьцонд металлын шинжилгээ хийх бол металл хямсаа ашиглахаас зайлсхийнэ. Бээлийтэй хуруугаар эсвэл ямар нэгэн төрлийн хямсаагаар фильтртэй ажиллах тохиолдолд сорьц цугларсан хэсэгт хүрэхээс зайлсхийнэ.

1.7 Масс агууламжийг тодорхойлох

Тоосонцрын масс агууламжийг дараах байдлаар тооцоолно.

$$C = \frac{(M_2 - M_1) - (B_2 - B_1)}{Vo}, \quad мг/м^3$$

- Энд С- тоос, тоосонцрын масс агууламж, мг/м3
- M_2- тоос цуглуулсны дараах фильтрийн жин, мг
- M_1- тоос цуглуулахын өмнөх фильтрийн жин, мг
- B_2- тоос цуглуулсан фильтрийг жигнэх үеийн бланк фильтрийн жин, мг
- B_1- тоос цуглуулах фильтрийн жигнэх үеийн бланк фильтрийн жин, мг
- V_o- Хэвийн нөхцөлд шилжүүлсэн соруулсан агаарын нийт эзэлхүүн, $м^3$

Тоос тоосонцрын масс агууламжийг тодорхойлсоны дараа сорьц бүхий фильтрт бусад химийн задлан шинжилгээг хийж болно.

2. АГААРЫН ТООСОНЦОРТ ОЛОН ЦАГИРАГТ ҮНЭРТ НҮҮРСУСТӨРӨГЧИД ТОДОРХОЙЛОХОД ЗОРИУЛЖ СОРЬЦЫГ ХАНДЛАХ АРГА

2.1. Уусгагчид

Ул мөрийн төдий агуулагдах бодисын шинжилгээнд хэрэглэгддэг өндөр цэвэршилттэй толуол, циклогексан, дихлорметан, ацетонитрил зэрэг уусгагчдыг ашиглана.

2.2. Хандлалт

Сорьцыг дараах аргуудаар хандална:

- Нэрлэгийн хандлалт
- Сосклетын хандлалт
- Түргэсгэсэн уусгагчийн хандлалт
- Ультрасоник чичиргээн хандлалт
- Богино долгионы хандлалт

Эдгээр аргуудын талаар доор тайлбарлав.

Дээрхи аргууд бүгд агаарын тоосонцорт агуулагдах олон цагирагт үнэрт нүүрстөрөгч болон бусад бодисыг органик уусгагчид уусгана. Хэрэв хандын эцсийн эзэлхүүн мэдэгдэж байгаа бөгөөд нэмэлт цэвэрлэх шат шаардлагагүй тохиолдолд масс детектортой хийн хроматограф (GC-MS) багаж ашиглан шинжилгээг шууд хийж болно. Флюресценц детектортой шингэний хроматограф багаж ашиглах бол хандыг хуурай болтол ууршуулж, тодорхой эзэлхүүнтэй ацетонитрил уусгагчид уусгана. Шаардлагатай бол хандыг концентрацижуулахаас өмнө цэвэрлэнэ. Хандад шууд шинжилгээ хийхгүй үед уусгагч уурших, бодис задралд орохоос сэргийлж 6ºC-аас бага харанхуй орчинд нэг сар хүртэл хугацаагаар хадгалж болно.

Энэхүү хандлалтын аргууд EN 15549, EN 15890 стандарт аргаар лабораторын болон хөндлөнгийн баталгаажуулалт хийгдсэн.

Хандлалтын явагдсаны дараа уусмалд фильтрийн болон тоосонцрын жижиг хэсгүүд байвал хандыг зохих фильтр (уусгагчаар урьдчилан угаасан шилэн хөвөн фильтр) - ээр шүүх шаардлагатай. Шүүх явцад гарах алдагдлаас сэргийлж хэрэглэгдэж байгаа материалыг уусгагчаар хангалттай зайлна.

Нэрлэгийн хандлалт:

Фильтрийг жижиг хэсгүүдэд хуваан, хайчилна. Фильтрийн хэсгүүдийг нэрлэгийн аппаратын доод колбонд байрлуулна. 7 мл толуол нэмж, хандлалтыг нэг цаг явуулна. Хөргөсний дараа хандыг пастерын пипитка ашиглан хуруу шилэнд шилжүүлнэ. Хандлалтын колбыг ойролцоогоор 3 мл орчим толуолоор гурван удаа зайлж, зайлсан уусмалуудыг ханд дээр нэмнэ. Масс спектрофотометр детектортой хийн хроматограф багажаар шинжлэх тохиолдолд хандыг цэвэр азотын зөөлөн урсгалд ойролцоогоор 1 мл хүртэл концентрацижуулна. Флюресценц детектортой шингэний хроматограф багажаар

шинжлэх тохиолдолд хандыг хуурай болтол болгоомжтой ууршуулж, үлдэгдлийг 1 мл эзэлхүүнтэй ацетонитрил уусгагчид уусгана.

Сокслет хандлалт:

Уусгагчаар угаасан хямсаа ашиглан фильтрийг сокслетын аппаратад байршуулна. Фильтрийг 200 мл орчим толуолоор хамгийн багадаа 20 цаг хандлана. Сорьцонд шууд гэрэл тусах, аппаратыг дулаан байлгаж хандлагийн циклийн цагийг багасгах зорилгоор аппаратыг мөнгөлөг цаасаар бүрнэ. Уусгагч хөрсөний дараа аппаратыг салгана. Үлдэгдэл уусгагчийг бөөрөнхий ёроолтой колбонд хийн, хадгална. Масс спектрофотометр детектортой хийн хроматограф багажаар шинжлэх тохиолдолд хандыг цэвэр азотын зөөлөн урсгалд ойролцоогоор 1 мл хүртэл концентрацижуулна. Флюресценц детектортой шингэний хроматограф багажаар шинжлэх тохиолдолд хандыг хуурай болтол болгоомжтой ууршуулж, үлдэгдлийг 1 мл эзэлхүүнтэй ацетонитрил уусгагчид уусгана.

Богино долгионы хандлалт:

Хандлалтыг богино долгионы задаргааны зуухыг ашиглан явуулна. Хандлалтыг зохистой явуулахын тулд үйлдвэрлэгчээс гаргасан багажны зааврыг мөрдөж ажиллана. Фильтрийг тефлон (политетрафторэтилен - PTFE) саванд хийж, 15 мл уусгагч нэмнэ. Хандлалтын дараа, сорьцтой тефлон савыг онгойлгохоос өмнө өрөөний температур хүртэл хөргөнө. Масс спектрофотометр детектортой хийн хроматограф багажаар шинжлэх тохиолдолд хандыг цэвэр азотын зөөлөн урсгалд ойролцоогоор 1 мл хүртэл концентрацижуулна. Флюресценц детектортой шингэний хроматограф багажаар шинжлэх тохиолдолд хандыг хуурай болтол болгоомжтой ууршуулж, үлдэгдлийг 1 мл эзэлхүүнтэй ацетонитрил уусгагчид уусгана.

Хандлалтыг 400 В-д 20 минутын турш явуулна (8 сав).

Түргэсгэсэн уусгагчийн хандлалт:

:Хандлалтыг зохистой явуулахын тулд үйлдвэрлэгчээс гаргасан багажны зааврыг мөрдөж ажиллана. Уусгагчийн хэмжээг багасгахын тулд элс хэрэглэж болно. Фильтрийг хандлалтын камерт (extraction cell) байршуулж 120ºС, 140 бар даралтад 5 минутын турш хандлана. Хандлалтыг гурван удаа явуулна. Үлдэгдэл хандууд автоматаар нэмэгдэнэ. Масс спектрофотометр детектортой хийн хроматограф багажаар шинжлэх тохиолдолд хандыг цэвэр азотын зөөлөн урсгалд ойролцоогоор 1 мл хүртэл концентрацижуулна. Флюресценц детектортой шингэний хроматограф багажаар шинжлэх тохиолдолд хандыг хуурай болтол болгоомжтой ууршуулж, үлдэгдлийг 1 мл эзэлхүүнтэй ацетонитрил уусгагчид уусгана.

Ультрасоник хандлалт:

Фильтрийг жижиг хэсгүүдэд хуваан, хий алдахгүй таглаатай шил саван байршуулна. Фильтрийн хэсгүүдэд 5 мл уусгагч нэмж, таглана. 10ºС-д 15 минутын турш ультросоник баннд хандлана. Хандыг дээр дурьдсан аргачлалын дагуу шүүнэ. Фильтрийг үлдэгдлийг дахин хоёр удаа хандлана. Шүүсэн гурван хандыг нийлүүлнэ. Масс спектрофотометр

детектортой хийн хроматограф багажаар шинжлэх тохиолдолд хандыг цэвэр азотын зөөлөн урсгалд ойролцоогоор 1 мл хүртэл концентрацижуулна. Флюресценц детектортой шингэний хроматограф багажаар шинжлэх тохиолдолд хандыг хуурай болтол болгоомжтой ууршуулж, үлдэгдлийг 1 мл эзэлхүүнтэй ацетонитрил уусгагчид уусгана.

2.3. Тохирох уусгагчууд

Хүснэгт 1. Хандлалтанд тохиромжтой уусгагчуудын мэдээлэл

Хандлалтын арга	Уусгагч
Нэрлэгийн	толуол
Сосклетын	толуол, гексан/ацетон холимог 1:1, дихлорметан
Богино долгионы	гексан/ацетон холимог 1:1
Түргэсгэсэн уусгагчийн	толуол, дихлорметан, дихлорметан/гексан холимог 1:1
Ультросоник	дихлорметан, толуол

3. ТООСОНЦРЫН СОРЬЦЫН УСАН ХАНД БЭЛТГЭХ, УУСДАГ ИОНУУДЫН АГУУЛГЫГ ТОДОРХОЙЛОХ

Аргын үндэс: Сорьц дахь ионуудын тооны болон чанарын анализ хийх янз бүрийн аргууд байдаг. Эдгээрээс хамгийн түгээмэл ашиглагддаг төхөөрөмж бол ион хроматограф юм. Хроматографийн аргын үндэс нь хөдөлгөөнт болон хөдөлгөөнгүй гэсэн 2 фазын тусламжтайгаар хольц дахь бодисуудыг ялгахад оршдог. Сорьцыг төхөөрөмжид өгсний дараа хөөгч уусмалаар туугдан ион ялгах баганад очно. Ялгагч баганын цэнэглэгдсэн хөдөлгөөнгүй фазын үйлчлэлээр сорьц дахь ионууд цуваанд ордог. Эдгээр цуваанд орсон ионууд нь детекторoор бүртгэгдэхдээ хугацааны хувьд цуваа үүсгэсэн хроматограммуудыг харуулдаг. Хэмжилт эхлэхийн өмнө олон цэгт калибровк хийх ба системийн ажиллагааг шалгахын тулд дотоод стандарт ашиглана. Агаарын тоосонцрын массыг бүрдүүлэгч голлох ионууд нь усанд уусах шинж чанартай байдаг ба сорьцыг усан орчинд хандалж шинжилгээг гүйцэтгэдэг.

3.1. Багаж хэрэглэл, шил сав

- Ионы хроматографийн систем
- 50 мл-ийн хуруун шил
- Сэгсрэгч эсвэл ультра соникатор
- Нэг удаагийн 0.45мкм-ийн мембран шүүлтүүр, тариур
- 25 мл хэмжээст колбонууд

3.2. Урвалж бодис

- Метан сульфоны хүчил (катионы хөөх уусмал) х.ц
- Натрийн гидроксид (Анионы хөөх уусмал) х.ц
- 7 анионы холимог стандарт уусмал
- 6 катионы холимог стандарт уусмал
- Ионгүйжүүлсэн ус

3.3. Сорьц хандлах, шинжилгээ хийх.

50 мл-ийн хуруун шилэнд сорьц бүхий филтрээс тоосонцрын хэмжээнээс хамааруулан 2×2 см-ээс багагүй хэмжээтэй хэрчиж хийгээд 20 мл ионгүйжүүлсэн ус хийж 30 минут ультра соникатор багажинд хандална. Хэмжилт хийхийн өмнө сорьцын уусмалыг нэг удаагийн 0.45 мкм-ийн мембран шүүлтүүрээр шүүгээд ионы хроматографаар сорьцон дахь анион, катионы агууламжийг жиших муруй ашиглан тодорхойлно. 50 дээж тутамд нэг хоосон сорьц хандалж шинжилнэ.

3.4. Шинжилгээний дүнг тооцоолох:

Агаар дахь *i* ионы агууламж C_i-г дараахь томъёогоор олно.

$$C_i = \frac{C \times n \times 20}{V \times 1000}$$

Энд:

C_i - агаар дахь i ионы агууламж, мг/м^3

V - соруулсан агаарын эзлэхүүн, м^3

C - сорьцон дахь i ионы агууламж, мг/л

n- фильтрийн нийт талбай ба хандлалтанд авсан хэсгийн талбайн харьцаа

4. АГААРЫН ТООСОНЦРЫН СОРЬЦЫГ ХҮЧЛИЙН ХОЛИМГООР БИЧИЛ ДОЛГИОНЫ ЗУУХ АШИГЛАЖ ЗАДЛАХ, МЕТАЛЛЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Аргын зарчим: Богино долгионы зуух ашиглан тоосонцор бүхий кварцын шилэн фильтрээс органик бус бодисыг хүчилд уусгана. Сорьцыг ингэж уусмалд шилжүүлсний дараа ICP, ICP / MS, FAA, GFAA зэрэг багажаар металлуудын агуулгыг тодорхойлно.

Саад болох хүчин зүйлс:

Орчны агаарын кварцын шилэн шүүлтүүрийг тоосонцрын материалыг дотогшоо уртааш нь хагас нугалж, хамгаалалтын дугтуйнд хийж авах ёстой. Дугтуй бүхий дээжийг шинжилгээ хийх хүртэл 15-30°C-д хадгална.

Сорьцыг хадгалах хамгийн их хугацаа 180 хоног байна. Сорьцыг 180 хоногийн дотор шинжилнэ.

Агаарын тоосонцрын сорьцийг таслан авахдаа сорьц гэмтэх, бохирдохоос сэргийлэх ба сорьцийг бүрэн уусгах, жингийн алдагдалгүй байхад анхаарна.

4.1. Хэрэглэгдэх материал, урвалжууд:

Бичил долгионы зуух ба бусад материал

- Бичил долгионы систем. 600 ватт хүртэл чадлын, програмчлагдах тохируулгатай, цахилгааны тогтвортой, сайн эх үүсвэртэй байх.

  [Анхааруулга: Хүнсний болон гэр ахуйн хэрэглээний богино долгионы зуухыг дээж боловсруулахад ашиглаж БОЛОХГҮЙ. Зуухны хөндий нь зэврэлтэнд тэсвэртэй, агааржуулалт сайтай байх ёстой. Аюулгүй ажиллагааны хувьд бүх цахилгаан хэрэгслийг зэврэлтээс хамгаалсан байх ёстой.]

- PFA Teflon® дээж задлах сав. 120 psi хүртэлх даралтыг тэсвэрлэх чадвартай. 120 psi (60-120 мл багтаамжтай) -аас дээш даралттай үед даралтыг хянах сав
- Teflon® PFA задраагааны сав. (60-120 мл багтаамжтай), битүүмжлэл маш сайн байх.
- Эргэдэг тавиур. Зуухны доторх дээжийг жигд хөдөлгөх.
- Хэмжээст цилиндр. 50-100 мл багтаамжтай (боросиликат).
- Дээж хадгалах зориулалттай шил, полиэтилен эсвэл нэвчилтгүй бүрхүүлтэй полипропилен сав.
- Центрифугийн хоолой. 50 мл полипропилен хоолой, полипропилен эргэдэг таглаатай.
- Nylon эсвэл Teflon® 0.45 μм тариурын шүүлтүүр.
- Угааж бэлтгэсэн 15 мл полипропилен хоолой, полипропилен шураг таглаатай.
- Пипетка. 0.1 мл ба түүнээс дээш нарийвчлалтай, эсвэл автомат пипетк.
- Хамгаалалтын маск. Сорьц бүхий фильтрийг огтлох үед өмсөх.
- Хэмжээст тавиур. Фильтрийг огтлоход хэрэглэнэ.
- Пицца таслагч, нимгэн дугуй. Ирийг тогтмол цэвэрлэнэ (<1 мм зузаантай).

- Эргүүлэгтэй холигч (vortex mixer).
- Давсны хүчил. Анализын цэвэр буюу түүнээс дээш цэвэршилттэй.
- Азотын хүчил. Анализын цэвэр буюу түүнээс дээш цэвэршилттэй
- Ионгүйжүүлсэн ус (Milli Q буюу түүнтэй дүйцэхүйц)
- Хандлах уусмал (5.55% HNO_3 / 16.75% HCl). ~ 500 мл-ийн ионгүйжүүлсэн усан дээр 55.5 мл концентрацитай HNO_3, 167.5 мл концентрацитай HCl-ийг нэмж, ионгүйжүүлсэн усаар нэг литр хүртэл шингэлж бэлтгэнэ.

4.2. Ажлын явц:

Фильтр таслаж авах.

- Лавлагаа аргад заасны дагуу суурь ба зүсэгч ашиглаж 8 "x 10" фильтрээс 1 "x 8" туузан хэлбэртэй хайчилж авна. Лабораторийн бичил долгионы хандлах системийг ашиглан металлыг давсны/азотын хүчлийн уусмалаар уусгана. Хөргөсний дараа шингэнийг сайтар хольж, уусдаггүй материалыг зайлуулахын тулд тариурын шүүлтүүр ашиглан шүүнэ. Уусмалыг ICP, ICP/MS, FAA, GFAA-аар шинжлэнэ.
- Хэрэглэхийн өмнө шүүх хэрэгсэл, полисульфоны центрифугийн хоолой, таг болон бусад лабораторийн хэрэгжлүүдийг дээжийн бохирдуулахаас сэргийлэн хүчлээр угаана.
- Гялгар уутан (винил) бээлий ашиглан фильтрийг гэрнээс гаргаж хувуурит сууринд тавина.
- Дээжийг бохирдлоос урьдчилан сэргийлэхийн тулд суурь, бүрхүүл, зүсэх хутгыг цэвэр, хуурай Kimwipe®-ээр арчина.
- Хуваах 8 "x 10" кварцын шүүлтүүрийг гаргаж, дээж авсан талыг дээш харуулан шүүлтүүрийн сууринд болгоомжтой байрлуулна.
- Хайч эсвэл зүсэгч ашиглан 1 "x 8" хэмжээтэй тууз хэлбэртэй хайчилж авна.
- Бээлийтэй гараар баян хуурыг хэлбэрт нугалж эсвэл сайтар хуйлж, арилдаггүй харандаагаар тэмдэглэсэн, хүчлээр цэвэрлэсэн полисульфон® хоолойд хийнэ. Богино долгионы зууханд бар код, бусад материал бүхий шошго ашиглаж болохгүй.
- Шүүлтүүрийн суурь, хайя зэргийг хуурай Kimwipes® ашиглан сорьц хооронд цэвэрлэнэ. (Сорьцын харилцан бохирдлыг багасгахын тулд 50 сорьц тутамд бээлийг солих хэрэгтэй.)
- 20 дээж тутамд 1 давталттай дээж байна.
- Хоосон сорьцоор судалгаанд ашигласан фильтрийг хэрэглэнэ. Металл тодорхойлох зориулалттай фильтрийн тууз авахаас гадна мөн тодорхой концентрацитай металл нэмж шинжилж, аргыг шалгаж болно (spike).
- Хоосон сорьцыг 20 дээж тутамд 1 давтамжтай авах, эсвэл задаргаа хийх өдөр бүр хамгийн багадаа 1 хоосон дээж байхаар бэлтгэнэ.

PFA савыг цэвэрлэх арга

Задаргааны бүх савыг хэрэглэхээс өмнө хүчлээр цэвэрлэж, нэрмэл усаар зайлж угаана. Ингэхдээ:

- PFA сав бүрийг зориулалтын савангаар угааж, нэрмэл усаар зайлна.
- Сав бүрт 10 мл концентрацитай HNO_3 нэмж, таглаад богино долгионы зууханд хийнэ.
- Богино долгионы зуухыг зааврын дагуу 10 минутын турш 100% -ийн хүчээр халаана. Аливаа шинжилгээнд ашиглахын өмнө савыг заавал цэвэрлэж, нэрмэл усаар их хэмжээгээр зайлж угаана.

Орчны тоосонцрын фильтр сорьцыг бичил долгионы зууханд задлах

[**<u>Анхааруулга</u>:** Азотын хүчил, давсны хүчлийн уур хортой. Иймд татах шүүгээнд ажиллана. Эдгээр урвалжуудын уусмал бэлтгэхэд экзотерм урвал явагдаж, дулаан ялгарна. Удаанаар хутгана.]

6.2.5.1 Винил бээлий эсвэл хуванцар хямсаа ашиглан фильтрийн туузыг хэрчиж аваад, шошготой PFA хоолойд байрлуулна. Хуванцар хямсаа ашиглан фильтрийг PFA хоолойн доод хэсэгт дарж хүчилд бүрэн далд орохуйц болгоно.

[Анхааруулга: Хуурай фильтртэй ажиллах үед аюулгүй байдлыг хангах үүднээс маск, винил бээлий заавал хэрэглэнэ.

Маск нь шилэн хөвөнгийн хэлтэрхий, тоосонцор материалыг амьсгалахаар нэвтрэхээс сэргийлдэг. Бээлий нь арьсыг мөн материалаас хамгаалж, дээжийг арьснаас элдэв бохирдол орохоос хамгаалдаг. Хэрэв боломжтой бол ламинар шүүгээнд фильтрийг зүсэх, шилжүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгтэй.]

[Анхааруулга: Шүүлтүүрээс нэгээс илүү хэсэгчилсэн дээж тасалж авах хэрэгтэй бөгөөд түүвэр ба QC шинжилгээнд хангалттай хэмжээний эзэлхүүнтэй байх ёстой. Хоосон шүүлтүүрийн дээжийг мөн адил аргаар боловсруулж гарсан үр дүн дээжийн үр дүнгээс хасаж тооцно.]

6.2.5.2 Using a preset calibrated automatic dispensing pipette or Class A glass pipette, add 10.0 mL of the extraction solution to each of the centrifuge tubes. The acid should cover the strip completely. The sequence of adding the filter strip and acid to the centrifuge tube may be reversed, if more convenient, without affecting the results. Place the centrifuge tube in a Teflon® PFA vessel containing 31 mL of deionized water. Continue this process for a total of 12 samples to maximize microwave capacity.

6.2.5.3 Place the PFA vessel caps with the pressure release valves on the vessels hand-tight and tighten using the capping station to a constant torque of 12 ft-lb. Weigh and record the capped

vessel assembly to the nearest 0.01 g. Place the vessels in the microwave carousel. Connect each sample vessel to the overflow vessel using the Teflon® PFA connecting tubes (see Figure 3).

6.2.5.4 Place the carousel containing the 12 vessels onto the turntable of the microwave unit. Any vessels containing 10 mL of acid solution for analytical blank purposes are counted as sample vessels. Irradiate the sample vessels at 486 W (power output) for 23 min. (Based on the calibration of the microwave as previously described). If fewer than 12 samples are to be digested, adjust the microwave system by reducing the power so that equivalent digesting power is delivered to the smaller sample batch. Generally, each vessel represents approximately 5% power. Therefore, a reduction in W would be reduced by 30% if only 6 vessels are digested. This reduction is only approximate, and each microwave unit will produce a different level of power output.

6.2.5.5 At the end of the microwave program, allow the pressure to dissipate (venting may be utilized with caution), then remove the carousel containing the vessels and cool in tap water for 10 min. Weigh the capped vessels assembly to the nearest 0.01 g and compare to the initial weight to verify no loss of sample. The initial and final weights should compare within 0.1 g. If the initial and final weights do not agree within 0.01 g, the appropriate action must be taken which may include rejecting the digested sample. Using the capping station uncap the microwave vessels, remove the labeled centrifuge tubes containing samples and discard the water in the PFA vessels.

6.2.5.6 Using a calibrated automatic dispensing pipette or a Class A glass pipette, add 10 mL of

deionized distilled water to each centrifuge tube. Cap the centrifuge tube tightly and vortex (mix) the contents thoroughly for 2-3 minutes to complete extraction. Using a nylon or teflon syringe pull-up a volume of sample from the centrifuge tube, place Acrodisc filter on syringe and dispense into a prelabeled sterile 15 mL centrifuge tube. Continue until the centrifuge tube contains 10 mL of filtered digestate.

6.2.5.7 The final extraction volume is 20 mL based upon the above procedure. The final extraction solution concentration is 3% HNO3/8% HCl. The filtered sample is now ready for analysis. Store for subsequent analysis by one or more of the Inorganic Compendium methods.

Хавсралт 1.

Зураг 1: Десикатор

Зураг 2: Их эзэлхүүнт сорьц авагч авагч

Ашигласан материал

1. Агаарын чанарын хяналт шинжилгээний гарын авлага. БОАЖЯ 2018 он
2. U. S. Environmental Protection Agency, Compendium of Methods for the Determination of Inorganic Compounds in Ambient Air (EPA/625/R-96/010a), 1999.
3. European committee for standardization, Technical Specification CEN/TS 16645, Ambient air - Method for the measurement of benz[a]anthracene, benzo[b]fluoranthene, benzo[j]fluoranthene, benzo[k]fluoranthene, dibenz[a,h]anthracene, indeno[1,2,3- cd]pyrene and benzo[ghi]perylene, 2014. English version
4. ISO international standard, ISO 16362, Ambient air — Determination of particle phase polycyclic aromatic hydrocarbons by high performance liquid chromatography, 2005.
5. U. S. Environmental Protection Agency, Compendium Method TO-13A, Determination of Polycyclic Aromatic Hydrocarbons (PAHs) in Ambient Air Using Gas Chromatography/Mass Spectrometry (GC/MS), 1999.

Хавсралт 2. Агаарын чанарын судалгаанд түгээмэл ашиглагддаг фильтрүүдийн тодорхойлолт

Фильтрийн төрөл, үйлдвэрлэгч	**Фильтрийн хэмжээ**	**Физик шинж чанар**	**Химийн шинж чанар**	**Шинжилгээний аргууд [a]**
Цагаригт суурилуулсан тефлон мембран фильтр (Ringed Teflon membrane)	- 25 мм - 37 мм - 47 мм	- Фильтр тэгш гөлгөр гадаргатай. - Тоос барих үр ашиг өндөр. - Хайлах температур ~60°C. - Агаар нэвтрүүлэх эсэргүүцэл өндөр. - Сүвшилт 2 мкм - Статик цэнэг үүсдэг.	- Цэвэршилт өндөр. - Ямар нэг хий шингээдэггүй - Ус шингээх чанар бага.	Жингийн , IC, ICP/MS, ICP/OES
Тефлон мембран (Teflon Membrane)	- 47 мм	Зузаан полипропиленд суурилуулсан мембран фильтр - Цагаан тэгш гөлгөр гадаргатай. - Тоос барих үр ашиг өндөр. - Хайлах температур ~60°C. - Агаар нэвтрүүлэх эсэргүүцэл өндөр.	- Цэвэршилт өндөр. - Нүүрстөрөгч агуулсан материалаар хийсэн тул нүүрстөрөгчийн шинжилгээнд тохиромжгүй - Ямар нэг хий шингээдэггүй. - Ус шингээх чанар бага.	Жингийн, INAA, AAS, ICP/AES, ICP/MS, IC, AC
Нилон мембран фильтр, (Nylon membrane)	- 25 мм - 37 мм - 47 мм	Цэвэр нилон мембран - Цагаан тэгш гөлгөр гадаргатай - Сүвшилт 1 нм - Хайлах температур ~60°C. - Агаар нэвтрүүлэх эсэргүүцэл өндөр.	- HNO_3 дээжлэх чадвар сайн. - Ус шингээх чанар бага	IC, AC
Мөнгөлөг мембран фильтр (Silver membrane)	- 25 мм[b] - 37 мм[c]	Мөнгөний жижиг хэсгүүдээр жигд бүрж нийлэгжүүлсэн мембран - Цагаан саарал тэгш гөлгөр гадаргатай	- Химийн урвалжуудад идэвхгүй	Жингийн, XRD

		- Хайлах температур ~350°C. - Агаар нэвтрүүлэх эсэргүүцэл өндөр.	- Зарим органик уурыг шингээх чанартай. - Ус шингээх чанар бага	
Целлюлозын нитрат холимог эфир мембран фильтр (Cellulose esters membrane)	- 37 мм - 47 мм[d]	- Целлюлозын нитрат холимог эфир, целлюлозын ацетатын нимгэн мембран - Цагаан тэгш гөлгөр гадаргатай - Сүвшилт 0.025,0.05,0.1,0.22,0.30, 0.45,0.65,0.80, 1.2,3.0, 5.0, 8.0 мкм. - Хайлах температур ~70°C. - Агаар нэвтрүүлэх эсэргүүцэл өндөр.	- Бага зэрэг үнсний агуулгатай - Олон төрлийн органик уусгагчид уусдаг - Ус шингээх чанар бага	Жингийн, ОМ, ТЕМ, SEM, XRD t Biomedical applications
Поливинил хлорт мембран (Polyvinyl chloride membrane).	- 47 мм	- Целлюлозын нитратын нимгэн мембран - Цагаан тэгш гөлгөр гадаргатай - Сүвшилт: 0.2, 0.6, 0.8,2.0, 5.0 мкм - Хайлах температур ~50°C. - Агаар нэвтрүүлэх эсэргүүцэл өндөр.	- Зарим органик уусгагчид уусдаг - Ус шингээх чанар их	XRD
Поликарбонат мембран фильтр (Polycarbonate membrane)	- 47 мм[b]	- Нимгэн, гөлгөр поликарбонат гадаргуу нь капилляр сүвүүд нэвт гарсан - Тоосонцрыг хэмжээгээр нь ялгахад ашиглагддаг .	- Цэвэршилт өндөр. - Нүүрстөрөгч агуулсан материалаар хийсэн тул нүүрстөрөгчийн шинжилгээнд тохиромжгүй - Ус шингээх чанар бага	Жингийн, ОА, ОМ, SEM, XRF, PIXE

		- Зарим сүвшилт томтой фильтрийн хувьд тоосонцор барих үр ашиг бага, <70% - Цахилгаанждаг - Сүвшилт: 0.1,0.3,0.4,0.6, 1.0,2.0,3.0, 5.0, 8.0, 10.0, 12.0 мкм - Хайлах температур ~60°C. - Агаар нэвтрүүлэх эсэргүүцэл өндөр дунд зэрэг		
Кварц фильтр (Pure quartz-fiber)	- 25 mm - 37 mm - 47 mm - 20.3x25.4 cm	- Кварц материалаар хийгдсэн - Фильтрийн гадаргуу тэгш бус . - Тоос барих үр ашиг өндөр. - Хайлах температур >900°C. - Агаар нэвтрүүлэх эсэргүүцэл дунд зэрэг.	- Хөнгөн цагаан, цахиурын агууламж өндөр. - Органик уур шингээх шинж чанартай. - HNO_3, NO_2, SO_2 бага зэрэг шингээнэ - Ус шингээх чанар бага	ICP/AES, ICP/MS, IC, AC, T, TOR, TMO, TOT, OA
